

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

М.Баттулга

ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн бүс нутагт үүсэн нөхцөлд байдлын үед тусгай ажиллагаа явуулах үүрэг бүхий төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллагааг хуульчлан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэйг чухалчлан авч үзсэн болно.

Түлхүүр үг: Улсын хил, Хилийн аюулгүй байдал, Харилцан ажиллагаа.

Оршил

Олон улсын харилцаанд зөрчил хямрал намжаагүй, бүс нутгийн аюулгүй байдлын орчин, түүнд нөлөөлөгч хүчин зүйлүүд хувиран өөрчлөгдсөөр байна.

Улс орнуудын дотоод засаглалын доройтол, эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдал зэрэг нь томоохон эрсдэлийг дагуулах боллоо.

Ийм нөхцөлд улс орон бүр үндэсний аюулгүй байдлаа хангах, төрийн тогтолцоо, газар нутаг, хүн амаа аюул, эрсдэлээс сэргийлэн хамгаалах асуудалд өндөр ач холбогдол өгч, олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд ч гэсэн эдийн засгийн хямрал, нийгэм, улс төрийн тогтворгүй байдлууд өрнөсөөр байна.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал, түүний дотроос хилийн аюулгүй байдлыг хангах асуудал бүхий л цаг үед чухлаар тавигдаж ирсэн билээ.

Энэ талаар төрийн бодлогын хэмжээнд олон тулгамдсан

асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэсээр ирснийг та бид мэдэж байгаа.

Аюулгүй байдлаа хангах нь аливаа улс орон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хадгалан, идэвхтэй үйл ажиллагаа явуулж хөгжих чадвар, эрх ашгаа зохион байгуулалтаар гадаад, дотоод нөлөөллөөс найдвартай хамгаалах боломжоо хадгалж байхад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны цогц юм.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд " Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс мөн " гэж заасан байдаг.

Батлан хамгаалах бодлого бол аливаа улс төрийн бодлогын нэг онцгой төрөл бөгөөд үндэсний аюулгүй байдлаа хангах хүрээнд улс орноо аливаа халдлагаас хамгаалах чиглэлийг тодорхойлсон төрийн бодлого байдаг.

Түүний дотор хилийн аюулгүй байдлыг хангах асуудал чухал байр суурь эзэлдэг.

**Нэг. Хилийн аюулгүй
байдлыг хангах үйл ажиллагаа,
арга зам**

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдахыг хэлдэг.

Тэгвэл хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагддаг.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогоо тодорхойлохдоо "Хилийн талаар баримтлах бодлого нь үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн" гэж томъёолсон байдаг.

**1.2 Монгол Улсын төрөөс хилийн
талаар баримтлах бодлогын
үндсэн чиглэлд:**

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар:

- Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахих, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож байх;

- Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах;

- Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах;

- Хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах;

- Хилийн асуудлаар хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх;

- Улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх;

- Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах;

- Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх;

- Хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх;

- Эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцөлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах;

- Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх;

Энэ нь Монгол Улсын Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдлыг хангах дэд тогтолцоо байх эрх зүйн үндсийг тодорхойлсон явдал юм.

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, даяаршлын үйл явц, техник технологийн хөгжилд тулгуурласан үндэстэн дамнасан нийгмийн сөрөг үзэгдэл нэмэгдсэн, экологийн тэнцвэрт байдал алдагдсанаас шалтгаалан байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, хор хөнөөл улам бүр нэмэгдэж байгаа нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хил хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас бусад байгууллага, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхийг шаардаж байна.

1.3 “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”

Тус үзэл баримтлалын 4.1.3-д Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно,

4.1.9-д Гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бусад байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшнийг шинэ шатанд гаргана, “Төрөөс хийлийн талаар баримтлах бодлого”-ын 2.1-д Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэж тусган бодлогын чиглэлийг тодорхойлсон байдаг.

Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг.

Хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 36.2. дугаар зүйлд Улсын хил хамгаалах байгууллага энэ хуулийн 36.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчин, тагнуул, цагдаагийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана; 6 дугаар бүлгийн 49.2. дугаар зүйлд Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ гэж ерөнхий байдлаар тусгасан байна.

Өнөөдрийн байдлаар хил хамгаалах байгууллага нь бусад төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий

байгууллагууд /Цагдаа, Тагнуул, Онцгой байдал, Зэвсэгт хүчин г.м/-тай хамтран ажиллахдаа байгууллага, салбар, нэгж хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичиг, харилцан ажиллагааны төлөвлөгөөг удирдлага болгон үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулаад хэвшсэн байна.

Хилийн бүс, зурвас газар гамшигт үзэгдэл тохиолдсон үед авран хамгаалах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, нүүлгэн шилжүүлэх, татан гаргах, хүн малын гоц халдварт өвчний үед мэдээлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, тархалтыг хязгаарлах радио хордлогын үед голомтын бүсээс ард иргэдийг татан гаргах чиглэлээр Онцгой байдлын газартай;

Хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагааг явуулах, хилийн бүс, зурваст гэмт хэрэгтнийг эрэх, саатуулах ажиллагааг Цагдаа, Тагууулын албатай;

Монгол улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг тогтоон барих, таслан зогсоох, улсын хилийг халхлах, няцаах, хөөн гаргах ажиллагааг зэвсэгт хүчинтэй тус тус харилцан ажиллаж байна.

Дээрх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудад Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хамтран ажиллах эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна. Жишээ нь:

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх

төрийн тусгай алба мөн” гэж тодорхойлоод чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг 2 дугаар бүлэгт нэг бүрчлэн тогтоосон.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлд “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлоод мөн хуулийн 29, 33, 44 дүгээр зүйлүүдээр чиг үүрийг хуульчилсан.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлоод мөн хуулийн 6.2.2. агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах; 6.2.3. улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх; гэж чиг үүрэгт ерөнхийлөн тусгасан байна.

Дүгнэлт, санал

Дээрхээс дүгнэхэд тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн эрх зүйн зохицуулалт хангалттай бүрдээгүй байна гэж үзэж болохоор байна.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн бүс нутагт үүсэн нөхцөлд байдлын үед тусгай ажиллагаа явуулах үүрэг бүхий төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллагааг хуульчлан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй мэт харагдаж байна.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол улсын хилийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага,

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого

иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг хуулиар зохицуулах ач холбогдолтой гэж үзэж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017